

БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙГ АШИГЛАЛТАД
ОРУУЛАХ КОМИССЫН ДҮГНЭЛТ

2025 оны 01 сарын 21-ны өдөр

Дугаар 6А-016/2025

Улаанбаатар хот

Нэг. Удиртгал хэсэг

Монгол Улсын нийслэлийн Хан-Уул дүүргийн 24 дүгээр хороонд баригдсан өндөр төвөгшилтэй ангиллын зорьтой 16 давхар, 1 блок, 3 (гурав) агуулахтай, үйлчилгээтэй 80 (ная) айлын орон сууцны зориулалттай барилга байгууламжид Засгийн газрын 2021 оны 07 сарын 20-ны өдрийн 212 дугаар тогтоол, нийслэлийн Засаг даргын 2024 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн А/503 дүгээр захирамжийн шийдвэрээр байгуулагдсан 15 хүний бүрэлдэхүүнтэй барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисс 2024 оны 11 сарын 22-ны өдрөөс эхлэн 1 хоногийн хугацаанд ажиллан тухайн барилга байгууламж, түүний холбогдох баримт бичигт үзлэг шалгалт хийв.

Хоёр. Ерөнхий мэдээлэл

- 2.1. Барилгын ажлын зөвшөөрлийн гэрчилгээний огноо, 2021.09.16 дугаар, 514/2021
- 2.2. Барилга байгууламжийн зураг төслийн шифр дугаар ЕГ Шифр: YR-08/22
- 2.3. Захиалагч: Богдхан уулын Дархан цаазат газрын хамгаалалтын захиргаа УТҮГ оноосон нэр, 9070002032 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 9100369 регистрийн дугаар, Хаяг: Хан-Уул дүүрэг, Чингисийн өргөн чөлөө, 2-р хороо, Барилга архитектурын байр – 312, 342620, 342137 холбоо барих утас, bogdkhan@mpa.gov.mn цахим хаяг;
- 2.4. Барилгын ажлын гүйцэтгэгч: Хаад Хурд ХХК оноосон нэр, 9011818739 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 6580157 регистрийн дугаар, БУ12-661/20 барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрлийн дугаар, Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг 14-р хороо 14-р хороолол 4-18 тоот Хаяг, 96960007 холбоо барих утас, info@khaadkhurd.mn цахим хаяг;
- 2.5. Барилгын ажлын Туслан гүйцэтгэгч байгууллага: "Тет бюлдинг" ХХК оноосон нэр, 9011722117 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 6281265 регистрийн дугаар, БУ11-638/21 барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрлийн дугаар, Хаяг: Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 12-р хороо, 6-р бичил хороолол 16-р 52 тоот, 97111157 холбоо барих утас, zoloo1157@gmail.com цахим хаяг;
- 2.6. Барилга байгууламжийн зураг төсөл зохиогч байгууллага: "Ягшуур" ХХК оноосон нэр, 9011486038 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 5844266 регистрийн дугаар, 3Т11-245/21 барилгын ажил гүйцэтгэх тусгай

ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН
ГАЗАР

Барилга байгууламжийг ашиглалтад
оруулах комисс

зөвшөөрлийн дугаар, Хаяг: Улаанбаатар хот, Баянгол дүүрэг 16-р хороо, 4-р хороолол, 49, 04 тоот 91997107 холбоо барих утас;

2.7. Барилга байгууламжийн ашиглагч, өмчлөгч байгууллага: Глобал Бридж Констракшн” ХХК 5838665 регистрийн дугаартай, Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, Чингисийн өргөн чөлөө-6 Хаан банк цамхаг 9 давхар, 99115884 холбоо барих утас, contract@gbconstruction.mn цахим хаяг;

2.8. Барилга байгууламжийн төлөв байдал: **Шаардлага хангасан**

Гурав. Дүгнэлтийн хэсэг

Барилга байгууламжийг ашиглалтад оруулах:

- Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д заасан шаардлагыг хангасан барилгын ажил зохих зөвшөөрөл, зураг төслийн дагуу бүрэн хийгдэж, хууль тогтоомжид заасан шаардлагыг хангасан тул

Барилга байгууламжийг ашиглалтад оруулахаас татгалзах:

- Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д заасан шаардлагыг хангаагүй, барилгын ажил зохих зөвшөөрөл, зураг төслийн дагуу бүрэн хийгдээгүй, хууль тогтоомжид заасан шаардлагыг хангаагүй тул

- Заасан хугацаанд үүрэг даалгаврын биелэлт хангаагүй тул

3.1 Энэ өндөр төвөгшилтэй ангиллын зорьтой 16 давхар, 1 блок, 3 (гурав) агуулахтай, үйлчилгээтэй 80 (ная) айлын орон сууцны зориулалттай барилга байгууламж түүний холбогдох баримт бичигт үзлэг шалгалт хийж, барилгын ажлын гүйцэтгэл, чанарт үнэлгээ, дүгнэлт өгсний үндсэн дээр комиссоос ДҮГНЭСЭН нь:

Энэ барилга байгууламжийн барилгын ажил зохих зөвшөөрөл, зураг төслийн дагуу бүрэн хийгдэж, хууль тогтоомжид заасан шаардлагыг хангасан гэж үзээд ашиглалтад оруулах нь зүйтэй гэж дүгнэв.

3.2 Барилга байгууламжийг ашиглалтад оруулах болсонтой холбогдуулан захиалагч, гүйцэтгэгч, зураг төсөл зохиогч байгууллагуудад даалгах нь:

а) барилга байгууламжийн иж бүрэн баримт бичгийн эх хувийг архивт, үлдэх хувийг ашиглагч буюу өмчлөгч, эзэмшигч байгууллагад ... хоногийн дотор багтаан шилжүүлэх;

б) барилга байгууламжийг ашиглалтад зүгшрүүлэх, тохируулах хугацаанд ашиглалтын хэвийн нөхцөлийг хангах болон уг хугацаа дуусгавар болохтой холбоотой хууль тогтоомжид заасан үйл ажиллагааг хэрэгжүүлэх.

3.3 Ашиглагч байгууллагад:

а) барилга байгууламжийг ашиглалтад зүгшрүүлэх, тохируулах хугацааг дуусгавар болгоход оролцох;



- б) барилга байгууламжийн хувийн хэргийг хөтөлж эхлүүлэх;
- в) барилга байгууламжийн хэвийн ашиглалттай холбоотой хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг үүгээр даалгаж байна.

3.4 Комиссын акт 3 хуудас, хуралдааны тэмдэглэл 5 хуудас, комиссоос өгсөн үүрэг даалгаврын биелэлтийн жагсаалт 30 хуудас материал болон барилга байгууламжийн бичиг баримтын жагсаалт болох материалыг дүгнэлтэд хавсаргаж байна.

Дөрөв. Дүгнэлтийн баталгаажуулалт

4.1 Өндөр төвөгшилтэй ангиллын зорьтой 16 давхар, 1 блок, 3 (гурав) агуулахтай, үйлчилгээтэй 80 (ная) айлын орон сууцны зориулалттай барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүгнэлт гаргасан.

Хан-Уул дүүргийн 24 дүгээр хороо, Богдхан уулын дархан цаазат газрын хамгаалалтын захиргаа УТҮГ-ын захиалгатай, зорьтой 16 давхар, 1 блок, 3 агуулахтай, үйлчилгээтэй 80 айлын орон сууцны зориулалттай

Комиссын дарга: Хяналт шалгалтын газрын Барилга байгууламжийн ашиглалт, бүртгэлийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч



(А.Мөнгөн)

Нарийн бичгийн дарга: Богдхан уулын дархан цаазат газрын хамгаалалтын захиргаа УТҮГ-ын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч



(Э.Цогбадрал)

Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын үүрэг даалгаврын биелэлтийн хуудасны хамт хүчинтэй.




ХАН-УУЛ ДҮҮРГИЙН 24 ДҮГЭЭР ХОРОО, Богдхан уулын Дархан цаазат газрын хамгаалалтын захиргаа УТҮГазар-ын /захиалагчийн мэдээлэл/ захиалгатай, 80 айлын /хүчин чадлын мэдээлэл/ орон сууцны /зориулалт/ БАРИЛГЫГ АШИГЛАЛТАД ОРУУЛАХ КОМИССЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

2024 оны 11 дүгээр сарын 22

Улаанбаатар хот

Хан-Уул дүүргийн 24 дүгээр хороо, Богдхан уулын Дархан цаазат газрын хамгаалалтын захиргаа УТҮГазар-ын /захиалагчийн мэдээлэл/ захиалгатай, 80 айлын /хүчин чадлын мэдээлэл/ орон сууцны /зориулалт/ барилгыг ашиглалтад оруулах комиссын хуралдаан тус барилгын 2 дугаар давхрын 10 тоот өрөөнд 2024 оны 11 дүгээр сарын 22-ны өдөр 13 цагт 15 гишүүний бүрэлдэхүүнтэй эхэлж, 15 цагт дуусав.



Хуралд:

- | | |
|---|-------------------------------|
| 1. Комиссын дарга: Хяналт шалгалтын газрын Барилга байгууламжийн ашиглалт, бүртгэлийн хэлтсийн дарга | О.Оджаргал |
| 2. Комиссын нарийн бичгийн дарга: Захиалагч | С.Хонгорзул |
| 3. Хяналт шалгалтын газар, Барилгын стандарт, аюулгүй байдлын хяналтын хэлтэс Барилга техникийн хяналтын улсын /ахлах/ байцаагч | Н.Ёндонсамбуу |
| 4. Хяналт шалгалтын газар, Дэд бүтцийн стандартын хяналтын хэлтэс, Эрчим хүчний хяналтын улсын ахлах байцаагч | 3. Очирпүрэв
Э. Ундрахцогт |
| 5. Улаанбаатар Дулааны сүлжээ ТӨХК | Ц.Билигт |
| 6. Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК, Техник хяналтын инженер | Н.Болор-Эрдэнэ |
| 7. Мэдээлэл Холбоо Сүлжээ ТӨХК | |
| 8. Ус сувгийн удирдах газар, Хэрэглэгчид үйлчлэх төвийн менежер | Д.Болормаа |
| 9. Онцгой байдлын ерөнхий газар /Нийслэлийн Онцгой байдлыг газар / | Б.Мягмаржав
Э.Шижиртуяа |
| 10. Үндэсний Төв Архив | |
| 11. Барилгын хөгжлийн төв, Норм, нормативын хэлтэс, Барилга байгууламжийг байнгын ашиглалтанд хүлээн авах, Норм нормативын сангийн бүрдүүлэлт хариуцсан мэргэжилтэн | О.Ундрах |
| 12. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах байгууллага, төлөөлөл | Д.Ганбат |
| 13. Ашиглалт хариуцах байгууллага | Г.Бямбасүрэн |
| 14. Зураг төсөл зохиогч байгууллага | Л.Мөнхжин |
| 15. Барилгын ажил гүйцэтгэгч | Д.Баянмөнх |

ИРЦИЙН БАЙДАЛ:

- Мэдэгдэл хүлээн авсан - 15
- Хүрэлцэн ирсэн - 14
- Хуралд оролцож үүрэг даалгаврын биелэлтээр санал гаргасан – 13

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

Хан-Уул дүүргийн 24 дүгээр хороо, Богдхан уулын Дархан цаазат газрын хамгаалалтын захиргаа УТҮГазар-ын /захиалагчийн мэдээлэл/ захиалгатай, 80 айлын /хүчин чадлын мэдээлэл/ орон сууцны /зориулалт/ барилгын ажлын баримт бичгийн бүрдэл, барилгын ажлын гүйцэтгэл нь ашиглалтад оруулах шаардлага хангасан эсэх талаар хэлэлцэв.

СОНССОН НЬ:

Комисст ажилласан гишүүд барилга байгууламжийн зураг төсөв, баримт бичиг, барилгын ажлын гүйцэтгэлийг хянаж танилцаад дараах саналуудыг гаргав.

Нийслэлийн хяналт шалгалтын газар, Барилгын стандарт, аюулгүй байдлын хяналтын хэлтэс, Барилгын техникийн хяналтын Улсын /ахлах/ байцаагч

Н. Ёндонсамбуу

- Лифтний албан шаардлага, биелэлтийн хамт үзүүлэх.
- Бетоны лабораторын шинжилгээг үзүүлэх.
- Техникийн давхарт зориулалтын дагуу ашиглах баталгаа гаргаж өгөх.
- Е4 сууцны өрөөний дуу тусгаарлагч акт үзүүлэх,
- Хөдөлмөрийн эрүүл ахуйн байцаагчаар дууг хэмжүүлж дүгнэлт гаргуулах, зураг төсөл зохиогч автор тайлбар албан тоот ирүүлэх
- Барилгын тухай хуулийн дагуу баталгаа албан тоот ирүүлэх.
- Захиалагч, гүйцэтгэгч, зураг төсөл зохиогчийг тодорхой болгох.
- Нийтийн эзэмшлийн коридорын цонхонд хязгаарлагч хийх.
- Тагтгүй айлд тайлбар албан тоот өгөх, арга хэмжээ авах.
- Орон сууцны суурийн хэсгийг бетонон хашлагыг бүрэн дуусгах.
- Зураг төсөл зохиогч унтлагын өрөөний хажууд лифт төлөвлөсөнд тайлбар.
- Барилгын ажлын гэрчилгээ дээрх зориулалтыг тодорхой болгох.
- Техникийн давхарт өргөтгөл хийсэнд тайлбар албан тоот өгөх.
- Дээврийн муудсан урагдсан хэсгийг засаж янзлах.

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтанд оруулах саналтай байна.

Барилгын стандарт, барилгын аюулгүй байдлын хяналтын хэлтсийн Барилгын техникийн хяналтын улсын байцаагч

3. ОЧИРПҮРЭВ

- 1-р худаг буюу огтолгооны худаг цэвэрлэн өөрийн салаа шугам будах, дулаалах, ус буулгагч хийх.
- 2-р худаг авто зам дээрх цөмөрсөн тагийг засварлан замын төвшинд янзлах, худаг цэвэрлэн, шат агаар гаргагч, ус юүлэгч дулаалга өнгийн туузаар ороох.
- 3-р худаг зургийн дагуу хийх.
- 4-р худаг зургийн дагуу люук хийх, шугам дулаалга, шат цэвэрлэгээ хийх.
- Батлагдсан Цэвэр, бохир дулаан хангамжийн зурагт дурдсан аж ахуйн нэгжүүдийн зөвшилцсөн албан бичгүүд шалгуулах.
- Техникийн давхрыг айлаар ашиглахгүй талаар захиалагч баталгаа гаргах.
- Нөөцийн савны ариутгал хийлгэн, ундны уснаас шинжилгээ өгч эрүүл ахуйн хяналтын улсын улсын байцаагчаар дүгнэлт гаргуулах.



- В1 давхарт зургийн дагуу агаар сэлгэлтийн шугам угсрах
- Дотор ХАС, ЦБУ-ны зургийг захиалагчийн дагуу нэршил өөрчлөх
- Техникийн давхарт нэмсэн өрөөнүүдийн ХАС, ЦБУ-ны гүйцэтгэлийн зураг шалгуулах, авторын дүгнэлтэд ашиглалтын хэвийн нөхцөлийг хангах талаар тусгуулах
- Дээвэр дээрх агаар сэлтгэлтийн шахтны хөндийг битүүлэн дулаалах, малгай доошлуулан үнэр гаргагч дулаалгатай өндөрлөх

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтанд оруулах саналтай байна.

Барилгын хөгжлийн төв ТӨҮГ-ийн инженер **О.Ундрах**

- Дээврийн дотуур усны хаялганы хог шүүгчийг тавьж техникийн давхрын усны буултыг буулгах
- Цоколийн гадна талын заслын ажлыг дуусгах
- С айлын тагтыг зураг төслийн дагуу гүйцэтгэх
- Барилгын тухай хуулийн 5.7.1-д заасны дагуу Норм, нормативын төлбөрийг тооцуулж төлөх
- Бетоны бат бэхийн дүгнэлтийг нөхөж үзүүлэх

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтанд оруулах саналтай байна.

Мэдээлэл холбооны сүлжээ ТӨХК-ийн инженер **Н.Болор-эрдэнэ**

- Гадна холбооны зурагт консол коренштэйн суурилуулах, цэвэрлэх, худгийн таг хүзүүг бэхлэх
- Гадна холбооны угсралтын акт нөхөж үзүүлэх
- Зоорийн давхарт кабелийн тавиур суурилуулах
- Бүх давхарт хяналтын камер суурилуулах
- Теле хяналтын ил далд ажлын акт шалгуулах
- Дотор холбоо дохиоллыг угсарсан компанийн тусгай зөвшөөрөл шалгуулах
- Ажлын самбаруудыг цэвэрлэх.

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтанд оруулах саналтай байна.

УС сувгийн удирдах газар, Хэрэглэгчдэд үйлчлэх төвийн менежер **Д.Болормаа**

- Гадна ЦБУ-ны шугамын трасс батлагдсан ажлын зургаас өөрчлөгдсөн тул зохиогчийн тайлбар дүгнэлт гаргуулах
- Барилга угсралтын ажлын зурагт 1500мм голчтой байхад 1000мм голчтой худаг угсарсан тул ажлын зургийн дагуу угсрах
- Ундны усны нөөцийн савны ус зайлуулах трапп хийж өгөх
- Техникийн нөхцлийн шаардлагад тусгасаны дагуу гадна цэвэр усны худагт галын гидрант суурилуулах
- Цэвэр бохир усны худагт шат бэхлэн суурилуулах

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтанд оруулах саналтай байна.

Улаанбаатар дулааны сүлжээ ТӨХК-ийн Шинэ хэрэглэгчдийн холболтын хэлтсийн дарга **Д.Сүхбат**

- Тухайлсан санал байхгүй.

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтанд оруулах саналтай байна.

Онцгой байдлын ерөнхий газар, Гал түймэртэй тэмцэх газар Гал түймрийн улсын хяналтын хэлтсийн барилгын зураг төсөл хяналтын тасгын дарга Дэд хурандаа

Б. Мягмаржав

- Гал түймрийн үеийн утаа зайлуулах хоолойн хаялтыг нормын дагуу засварлаж, агаар оруулах сараалж хийх. /Техникийн давхарт/
- Галын дотуур даралтат усны цэг “ГК” байнгын ажиллагаанд оруулах
- Орон сууцны С сууцны айл өрхөд хянагдсан зураг төслөөр тагт төлөвлөөгүй байна зохиогч тайлбар ирүүлэх
- Шатны хонгилын хаалганд өөрөө хаагдагч тоноглол хийх.

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтанд оруулах саналтай байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах байгууллага **Д. Ганбат**

- Үүднээс нийтийн эзэмшлийн талбайруу явган хүний замруу гарах налуу зам хийх
- Явган хүний замыг харааны бэрхшээлтэй иргэдэд зориулсан хөтөч зам хийх болон налуу талд нь хамгаалалтын хашлага хийх
- Үүрэг даалгаврын биелэлтийг фото зургаар баталгаажуулж өгөх үүрэг даалгавар өгсөн

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтанд оруулах саналтай байна.

Туул арвижих өргөө ХХК /ашиглагч/ **Г. Бямбасүрэн**

- Гадна, дотор инженерийн шугам сүлжээ батлагдсан ил далд ажлын акт холбогдох бичиг баримтын хуулбарыг иж бүрнээр хүлээлгэж өгөх.

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтанд авах саналтай байна.

Ягшуур ХХК /зураг төсөл зохиогч/ **Л. Мөнхжин**

- Зураг төсөлд тусгасан тагт хийх, дутууг гүйцээх

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтанд авах саналтай байна.

Хаад хурд ХХК /ерөнхий гүйцэтгэгч/ **Б. Баянмөнх**

- Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтанд оруулах саналтай байна.

Богдхан уулын дархан цаазат газрын захиргаа УТҮГ, Комиссын нарийн бичгийн дарга **С. Хонгорзул**

- Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтанд оруулах саналтай байна.

Биндэгноров ХХК-ийн инженер **З. Жавхлан**

- В1 давхарт техникийн өрөө гэсэн бичиглэлийн дээр цахилгааны өрөө гэсэн бичиглэлтэй болгох
- Цахилгааны өрөө гэсэн бичиглэлийн анхааруулах плакат тогтоох
- Гаднаас өндөр хүчдэлийн 0,4кв-ын кабель хаах кроштейн хийх
- Доогуур явсан кабелийн хаах хаалт хийх
- Кабелийн оруулга бүр дээр верк, хаягжуулалт хийх. Аль ХТП, яг гаргалаг, кабелийн марк, уртыг бичих
- Хувиарлах самбарын автоматаас гаргасан кабель болгон верк хаягжуулалт хийх

- Узелийн тоолуур тавих
- Техникийн нөхцөлийн дагуу ухаалаг тоолуур тавих.

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтанд оруулах саналтай байна.

Үндэсний төв архивын газар, Зураг төслийн баримтын ахлах архивч **Э.Шижиртуяа**

- Ил далд ажлын актыг бүрэн бүрдүүлэх, цаасанд хэвлэхдээ стандартын дагуу хэвлэн гаргаж, бичилт хийж баталгаажуулах
- Барилга угсралтын ажлыг гүйцэтгэсэн тэмдэглэлд гүйцэтгэгч байгууллага баталгаа гаргаж өгөх
- Хувийн хэрэгт дараах баримт бичгийг хавсаргах: Үүнд:
 - Зураг төсөл зохиогч байгууллагатай холбоотой төрийн эрх бүхий байгууллагаас олгосон холбогдох баримт бичиг.
 - Лифтэнд магадлал хийсэн тухай дүгнэлт техникийн магадлалын акт.
 - Барилга инженерийн байгууламжийн байрзүйн зургийг мэдээллийн санд бүртгүүлсэн акт, гүйцэтгэлийн зураг.
- Архивд баримт бичиг хүлээлгэн өгөх нийтлэг жагсаалтын дагуу баримт бичгийг бүрэн бүрдүүлэх, хуудас, дугаарлах, дотоод төвийг үйлдэх.
- Баримт бичиг болон ажлын зургийн эх хувийг архивт хүлээлгэн өгөх.

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтанд оруулах саналтай байна.

Комиссын дарга: Хяналт шалгалтын газрын, Барилга байгууламжийн ашиглалт, бүртгэлийн хэлтсийн дарга **О. Оджаргал**

- БНБД 11-04-16 дагуу зохиогч дүгнэлт бичих
- Барилгын тухай хуулийн дагуу барилгад чанарын баталгаа гаргаж албан тоотоор оруулах
- Техникийн давхрын зориулалтыг тодорхой болгох албан тоот ирүүлэх. зориулалтын дагуу ашиглах албан тоот ирүүлэх
- Комиссын гишүүдийн үүрэг даалгаврын биелэлийн хавсралтаа хянуулах
- Захиалагчийн дүгнэлт хянуулах


Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтанд оруулах саналтай байна.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Хан-Уул дүүргийн 24 дүгээр хороо, Богдхан уулын дархан цаазат газрын хамгаалалтын захиргаа УТҮГ-ын захиалгатай, зорьтой 16 давхар, 1 блок, 3 агуулахтай, үйлчилгээтэй 80 айлын орон сууцны зориулалттай барилгыг байнгын ашиглалтад оруулах комиссын гишүүдийн гаргасан үүрэг даалгаврын биелэлтийг хангуулах, биелэлтээр комиссын дүгнэлтийг баталгаажуулж, ашиглалтад оруулахаар шийдвэрлэв.

Танилцсан:

Хяналт шалгалтын газрын
Барилга байгууламжийн ашиглалт,
бүртгэлийн хэлтсийн даргын албан
үүргийг түр орлон гүйцэтгэгч



(А.Мөнгөн)

Тэмдэглэл хөтөлсөн:

Богдхан уулын дархан цаазат газрын
хамгаалалтын захиргаа УТҮГ-ын даргын
албан үүргийг түр орлон гүйцэтгэгч



(Э.Цогбадрал)

ЭНД